

ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Стратеги төлөвлөгөөний зорилго Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.1.5 дах заалт "Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж хэвшүүлнэ."							
1.	1.Бодлогын баримт бичиг тусгагдсан зорилт: Санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлэх санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх	Албаны үйл ажиллагааны зардал	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх	Эрсдэлийг үнэлэн хяналт шалгалт явуулсан	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт 3, дотоод аудит 6 хийж тайлагнасан байна.	Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт давхардсан тоогоор 45 байгууллагад төлөвлөгөөт 8 аудит, төлөвлөгөөт бус 2 хяналт шалгалт нийт 10 аудит хийсэн. Үүнээс 5	100

						дотоод аудит, 5 санхүүгийн хяналт шалгалт хийж 15 зөрчил дутагдал илрүүлэн 15 зөвлөмж хүргүүлсэн.	
1.1.1	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Хангай цогцолбор сургуулийн төсөв санхүүгийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт хийх	Албаны үйл ажиллагааны зардал	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх	Хангай цогцолбор сургуулийн 2020 оны 2-4-р улирал, 2021 оны 1-2-р улирлын санхүүгийн болон дотоод үйл ажиллагаанд үнэлэлт өгсөн. Тус аудитаар 5 зөвлөмж хүргүүлсэн. 2021 оны 8-р сарын 2-ны дотор албан бичгээр ирүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 98 хувьтай биелсэн байна.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд Хангай цогцолбор сургуулийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж тайлагнасан байна.	Төсвийн Ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд Хангай цогцолбор сургуулийн холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, заавар журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээнд санхүүгийн хяналт шалгалт хийх, дүгнэлт зөвлөмж өгөх эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр санхүүгийн хяналт шалгалтыг хийлээ. Хангай цогцолбор сургуулийн 2021 оны 3-4-р улирал, 2022 оны 1-2-р улирлын санхүүгийн болон дотоод үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт хийхэд 2022 оны хагас жилийн байдлаар анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэсэн, татварын ебаримт болох	100

						төлбөрийн баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй, тухайн аж ахуйн нэгж татварын системд ебаримтаа шивээгүй, хоол зүйч нь үдийн цайны өдөр тутмын түгээлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй зэрэг алдаа зөрчил гарсныг засаж сайжруулах талаар зөвлөлөө. Тус аудитын тайланд 2 зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 12-р сарын 10-ны дотор ирүүлэхээр байна	
1.1.2	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 207 дугаар	Албаны үйл ажиллагааны зардал	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх	207 дугаар цэцэрлэгийн 2021 оны 2-4-р улирлын санхүүгийн болон дотоод үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгсөн. Тус санхүүгийн хяналт шалгалтаар 4 зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийг	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд 207 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж тайлагнасан байна.	Төсвийн Ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд 207 дугаар цэцэрлэгийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, заавар журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээнд санхүүгийн хяналт шалгалт хийх, дүгнэлт зөвлөмж өгөх эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр	100

	<p>цэцэрлэгийн төсөв санхүүгийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт хийх</p>			<p>2021 оны 8-р сарын 2-ны дотор албан бичгээр ирүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 82,5 хувьтай биелсэн.</p>		<p>санхүүгийн хяналт шалгалтыг хийлээ. 207 дугаар цэцэрлэгийн 2021 оны 1-4-р улирал, 2022 оны 1-р улирлын санхүүгийн болон дотоод үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт хийхэд Татварын ебаримт болох төлбөрийн баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй, тухайн аж ахуйн нэгж татварын системд ебаримтаа шивээгүй, өмнө хийгдсэн шалгалтуудын алдаа зөрчлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулаагүй, нягтлан бодогчийг батлагдсан бүтэц орон тоогоор цалинжуулаагүй, төсвийн хөрөнгөөр сургалтад суучаад үр дүн үзүүлээгүй албан хаагчаас сургалтын төлбөрийг суутган аваагүй зэрэг алдаа зөрчил гарсныг засаж сайжруулах талаар зөвлөлөө. Тус аудитын тайланд 3 зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 7-р сарын 25-нд ирүүлсэн. Зөвлөмжийн</p>	
--	---	--	--	---	--	--	--

						хэрэгжилт 93,3 хувьтай байна.	
1.1.3	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 44 дүгээр цэцэрлэгийн төсөв санхүүгийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт хийх	Албаны үйл ажиллагааны зардал	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх	44 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 2-4-р улирал, 2021 оны 1-2-р улирлын санхүүгийн болон дотоод үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгсөн. Тус санхүүгийн хяналт шалгалтаар 3 зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 8-р сарын 2-ны дотор албан бичгээр ирүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 87,5 хувьтай биелсэн.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд 44 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж тайлагнасан байна.	Төсвийн Ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд 44 дүгээр цэцэрлэгийн холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, заавар журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээнд санхүүгийн хяналт шалгалт хийх, дүгнэлт зөвлөмж өгөх эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр санхүүгийн хяналт шалгалтыг хийлээ. 44 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 3-4-р улирал, 2022 оны 1-р улирлын санхүүгийн болон дотоод үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт хийхэд Татварын ебаримт болох төлбөрийн баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй, тухайн аж ахуйн нэгж татварын системд ебаримтаа шивээгүй, өмнө хийгдсэн шалгалтуудын алдаа	100

						зөрчлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулаагүй зэрэг алдаа зөрчил гарсныг засаж сайжруулах талаар зөвлөлөө. Тус аудитын тайланд 1 зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 12-р сарын 08-ны дотор албан бичгээр ирүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 89 хувьтай байна.	
1.1.4	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Илч-Орд ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн	Албаны үйл ажиллагааны зардал	Гүйцэтгэлийн аудит хийж үйл ажиллагаанд нь үнэлгээ дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх	Дүүргийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд 2021 оны 03.16–04.07-ны хооронд Илч-Орд ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийсэн. Илэрсэн асуудлын бүртгэлд 7 асуудлыг бүртгэж, 3 зөрчлийг	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд Илч-Орд ОНӨААТҮГ-ыг үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийж үнэлэлт дүгнэлт өгч тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд Илч-Орд ОНӨААТҮГ-ын 2022 оны 1,2,3-р улирлын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийж байна. Аудитын явцад байгууллагын удирдлага нягтлан бодогч хүний нөөц ХАБ инженертэй уулзан тайлбар тодруулга авч зөвлөгөө зөвлөмжийг өглөө. Байгууллагын засаглалын төлөвшлийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдээр асуулга авч баримтад тулгуулан үнэлэхэд 1-р түвшин буюу	100

	аудит хийх	аудит		тайланд тусгаж зөвлөмж хүргүүлсэн. Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай буюу 2-р төвшин”-д байна гэж үзэж “САЙЖРУУЛАХ ХЭРЭГТЭЙ” үнэлгээг өгч зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн байна.		Эхлэлтийн түвшинтэй үзүүлэлт 1, 4-р түвшин буюу удирдсан үнэлгээний түвшинтэй үзүүлэлт 7 байна. Засаглах удирдлага нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд салбарын бодлого стратеги, хөтөлбөр арга хэмжээг үнэлэхэд оролцдог ч эрсдэлийн удирдлага, хяналтын талаар зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалт байхгүй. Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 3-р түвшин буюу Томьёолсон үнэлгээг 7шалгуур үзүүлэлт хангасан байна. Эрсдэлийн талаар ойлголт байгууллагын хэмжээнд тогтсон, нэгдсэн ойлголтод хүрсэн, төрөл бүрийн эрсдэлийн бүртгэл болон эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүд ашиглаж байна. Мөн эрсдэлийн мэдээллийг нэгтгэж уялдуулсан боловч байгууллагын удирдлагын түвшинд бүрэн ашигладаггүй байна. Байгууллагын дотоод	
--	---------------	-------	--	--	--	--	--

						<p>хяналтын тогтолцооны төлөвшлийг хяналтын орчин, хяналтын үйл ажиллагаа, мэдээлэл дамжуулалт ба харилцаа, мониторингийн үйл ажиллагааны бүрэлдэхүүнээр шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлж дүгнэсэн.Хяналтын орчинг 5 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 4-р түвшин буюу Удирдсан шалгуур үзүүлэлтийг хангасан байна.Хяналтын үйл ажиллагааг 3 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 3-р түвшин буюу Томьёолсон шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Мэдээлэл дамжуулалт ба харилцааг 3 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 2 үзүүлэлт нь 2-р түвшин буюу Давтамжтай, 1 үзүүлэлт нь 4-р түвшин буюу Удирдсан шалгуурыг хангасан байна. Мониторингийг 2 шалгуур үзүүлэлтээр дүгнэхэд 3-р түвшин буюу Томьёолсон шалгуур үзүүлэлтийг хангасан байна.Дотоод хяналтыг голчлон хөдөлмөрийн аюулгүй байдал, санхүүгийн анхан</p>
--	--	--	--	--	--	---



						шатны баримтын бүрдүүлбэр, бараа материалын зарцуулалтад дотоод хяналт тавьж байна. Илэрсэн асуудлын бүртгэлд 2 асуудлыг оруулахаар нотолгоог бүрдүүлж тайлбар мэдээллийг холбогдох албан тушаалтнаас авсан Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай буюу 2-р түвшин”-д байна гэж үзэж “САЙЖРУУЛАХ ХЭРЭГТЭЙ” үнэлгээг өгсөн. Тус аудитын тайланд 2 зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийн хугацаа болоогүй байна.	
1.1.5	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл	Албаны үйл ажиллагааны зардал	Гүйцэтгэлийн аудит хийж үйл ажиллагаанд нь үнэлгээ дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх	Биеийн тамир, спорт хорооны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийлээ. Гүйцэтгэлийн аудитыг улсын салбарын дотоод	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд Биеийн тамир, спорт хорооны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийж	Дүүргийн Засаг даргын баталсан удирдамж, байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд Биеийн тамир, спорт хорооны 2022 оны 1-р улирлын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийж үр дүнг удирдлагад танилцуулсан. Даргын	100

	ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Биеийн тамир, спорт хорооны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийх			аудитын аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн. Нэгдсэн дүгнэлтээр Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшилт нь “давтамжтай буюу 2-р төвшин”-д байна гэж үзэж “САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТ АЙ” дүгнэлт өгсөн. АБ-3000 илэрсэн асуудлын бүртгэл хөтлөн 4 зөвлөмж өгч зөвлөмжийн хэрэгжилт 85 хувьтай хэрэгжсэн.	үнэлэлт дүгнэлт өгч тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.	тушаал алдаатай 8 шийдвэр зөрчлийг илрүүлэн асуудлын бүртгэл хөтлөн 6 асуудлыг аудитын явцад залруулж, 2 зөрчлийг тайланд тусгасан. Дотоод аудитаар Сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтийг өгсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.	
1.1.6	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар	Албаны үйл ажиллагааны зардал	Гүйцэтгэлийн аудит хийж үйл ажиллагаанд нь үнэлгээ дүгнэлт	Дүүргийн Засаг даргын баталсан удирдамжийн	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан	Гэр бүл хүүхэд залуучуудын хэлтсийн төсвийн ерөнхийлөн захирагч нь Хөдөлмөр	100

	<p>тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийх</p>		<p>өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх</p>	<p>хүрээнд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийсэн. Аудитаар 3 зөрчлийг илрүүлэн 3 зөвлөмж хүргүүлсэн. Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай буюу 2-р төвшин”-д байна гэж үзэж “САЙЖРУУЛАХ ХЭРЭГТЭЙ” үнэлгээг өгч зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.</p>	<p>удирдамжийн хүрээнд Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийж үнэлэлт дүгнэлт өгч тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.</p>	<p>нийгмийн хамгааллын яамны харьяанд шилжсэн. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч буюу дүүргийн Засаг даргад төсөв хамаарахгүй болсон учраас дүрмийн дагуу шалгалт явуулах боломжгүй болсон. Сангийн сайдын 2022 оны 2-р сарын 14-ний өдрийн хяналт шалгалт хийх нэгдсэн удирдамж, дүүргийн Засаг даргын 2022 оны 2-р сарын 16-ны өдрийн удирдамж, хөтөлбөрийн дагуу дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн байгууллагуудад 2016-2021 онд хууль бус шийдвэрийн улмаас төрийн албанаас халагдсан ажилтнуудад төсвөөс олгосон нөхөн олговор, түүнийг холбогдох хуулийн дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн эсэх асуудалд хяналт шалгалт хийсэн.</p>	
--	---	--	--	--	--	--	--

						Хяналт шалгалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээний орон нутгийн байгууллагууд ЗДТГазар, ХАААлба, ГБХЗХХэлтэс, Соёлын ордон, Багахангай тохижилт ОНӨААТҮГГазар, Илч-Орд ОНӨААТҮГГазар, ЖДҮДТөв ОНӨТҮГГазрууд хамрагдсан. Орон нутгийн байгууллагуудад Сангийн яамны удирдамжийн хавсралтаар батлагдсан судалгааны маягтыг цахимаар хүргүүлэн мэдээлэл цуглуулсан. Хяналт шалгалтад хамаарах асуудлаар Илч-Орд ОНӨААТҮГГазраас мэдээлэл ирүүлсэн бөгөөд холбогдох асуудлын баримтыг татан авч хянан шалгасан.	
1.1.7	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” Дүүргийн Засаг	Албаны үйл ажиллагааны зардал	Гүйцэтгэлийн аудит хийж үйл ажиллагаанд нь үнэлгээ дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх	Дүүргийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд Багахангай Тохижилт ОНӨААТҮГ-ын үйл	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд гүйцэтгэлийн аудитыг хийлээ. Гүйцэтгэлийн аудитыг улсын салбарын дотоод аудитын аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ. Аудитаар	100

	<p>даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Багахангай тохижилт ОНӨААТҮГ үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийх</p>			<p>ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийсэн. Аудитаар ДИТХТ-ийн “Хог хураамжийг шинэчлэн тогтоох тухай” Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй тогтоолыг дагаж мөрдсөн зөрчлийг илрүүлэн 1 зөвлөмж хүргүүлсэн. Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай буюу 2-р түвшин”-д байна гэж үзэж “САЙЖРУУЛАХ ХЭРЭГТЭЙ” үнэлгээг өгч зөвлөмжийн хэрэгжилт 100</p>	<p>үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийж үнэлэлт дүгнэлт өгч тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.</p>	<p>илэрсэн зөрчил дутагдлыг аудитын тайлангийн хугацаанд үүрэг өгч зөрчлийг засуулав. Нэгдсэн дүгнэлтээр Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай буюу 2-р түвшин”-д байна гэж үзэж “САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ” дүгнэлт өглөө. Зөвлөмжийн хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй байна.</p>	
--	---	--	--	--	---	---	--

				хувьтай байна.			
1.1.8	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийх	Албаны үйл ажиллагааны зардал	Гүйцэтгэлийн аудит хийж үйл ажиллагаанд нь үнэлгээ дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх	Дүүргийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийсэн. Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь тус бүрдээ “Удирдсан буюу 3-р түвшин”-ээс дээш байна гэж үзэж “Хангалттай дүгнэлт”-ийг өглөө. Санхүүгийн үйл ажиллагаанд материаллаг алдаа зөрчил илрээгүй	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийж үнэлэлт дүгнэлт өгч тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд гүйцэтгэлийн аудитыг улсын салбарын дотоод аудитын аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг аудитын тайлангийн хугацаанд үүрэг өгч зөрчлийг засуулав. Нэгдсэн дүгнэлтээр Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай буюу 2-р түвшин”-д байна гэж үзэж “САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ” дүгнэлт өглөө. Зөвлөмжийн хэрэгжилт 2022 оны 12-р сарын 30-ны өдөр ирүүлэхээр албан бичиг хүргүүлэв.	100

				санхүүгийн сахилга бат сайн байна.			
1.1.9	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 2021 оны санхүүгийн хяналт, дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд сэдэвчилсэн аудит хийх	Албаны үйл ажиллагааны зардал	Сэдэвчилсэн аудит хийж үйл ажиллагаанд нь үнэлгээ дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх	Багахангай дүүргийн Дотоод аудитын алба нь Дүүргийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудитын 2021 оны зөвлөмжийн хэрэгжилтэд 2021 оны 12-р сарын 14-ээс 2021 оны 12-р сарын 27-ны хооронд аудит хийсэн. Аудитаар засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь тус бүртээ	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд 2021 оны төлөвлөгөөнд хамрагдсан 4 санхүүгийн хяналт шалгалт, 7 дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд сэдэвчилсэн аудитыг хийж үнэлэлт дүгнэлт өгч тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.	Сангийн яамны чанарын хяналт шалгалтын явцад тухайн оны зөвлөмжид сэдэвчилсэн аудит хийх нь шаардлагагүй гэж зөвлөсөн. Иймд зөвлөмжийн хэрэгжилтийг явцыг байгууллага тус бүрээр биечлэн шалган удирдлагад илтгэх хуудсаар танилцуулахаар бэлтгэж байна.	90

				“удирдсан буюу 3-р түвшин”-ээс дээш байна гэж үнэлсэн. Аудитаар илэрсэн асуудлын 20% хүртэл нь “нөлөө ихтэй” гэж үзэн “ХАНГАЛТТАЙ” үнэлгээ өгсөн.			
2	Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт:Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх дотоод аудитын хороог байгуулан, хуулийн тогтоомжийн хүрээнд тусгайлсан дотоод аудитыг хийх	Албаны үйл ажиллагааны зардал	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн эхний хагас жил, жилийн эцсийн байдалд төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах 13 байгууллагуудыг хамруулан үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх, худалдан авах ажиллагаанд аудит хийх	Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2 удаагийн аудит, Худалдан авах ажиллагаанд 2 удаагийн аудит хийсэн	Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2 удаагийн аудит, Худалдан авах ажиллагаанд 2 удаагийн аудит хийж дотоод аудитын хороог шинэчлэн байгуулсан байна.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2021 оны жилийн эцсийн байдлаар 13 байгууллагад явууллаа. 2021 оны жилийн эцсийн байдлаарх шилэн дансны мэдээллийн үйл ажиллагаа, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн байдлыг Сангийн яамны боловсруулсан ажлын хүснэгтээр үнэлж дүгнэвэл Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 90,0%-тай биелсэн байна. 2022 оны 7-р сард шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2022 оны хагас жилийн байдлаар 13 байгууллагад	100



						явуулаа. 2022 оны хагас жилийн байдлаарх шилэн дансны мэдээллийн үйл ажиллагаа, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн байдлыг Сангийн яамны боловсруулсан ажлын хүснэгтээр үнэлж дүгнэвэл Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 92,4%-тай биелсэн байна. Аудитын хороог байгуулах захирамжийн төслийг удирдах албан тушаалтнуудаар хянуулж байна.	
2.1	Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар баталсан "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн 2 дах хэсэгт "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийг мөрдөж ажиллахыг төсвийн ерөнхийлөн	Албаны үйл ажиллагааны зардал	Дүүргийн дотоод аудитын хороог шинэчлэн байгуулна.	-	Дотоод аудитын хороог шинэчлэн байгуулан чиг үүргийн асуудлыг хэлэлцүүлнэ.	Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах түүний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан дотоод аудитын тайланг хэлэлцэн шийдвэрлэх үүрэг бүхий "Дотоод аудитын хороо"-г байгуулахаар төсвийн ерөнхийлөн захирагчид санал хүргүүлсэн. Захирамжийн төслийг удирдах албан тушаалтнуудаар хянуулж байна.	90

	захирагч нарт үүрэг болгосугай. заалтын хэрэгжилтийг хангах Дотоод аудитын хороог хууль тогтоомжид заасан бүтцийн дагуу шинэчлэн байгуулах						
2.2	Шилэн дансны тухай хуулийн 8.2 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ” “Дүүргийн Засаг	Албаны үйл ажиллагааны зардал	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн эхний хагас жилийн байдалд төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах 14 байгууллагуудыг хамруулан үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх	2021 оны 2-р сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2020 оны жилийн эцсийн байдлаар 13 байгууллагад явуулсан. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн байдлыг НТАГ боловсруулсан аргачлал, хүснэгтээр үнэлж дүгнэвэл Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган 2021 оны эхний хагас жилийн байдлаар төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах 13 байгууллагууд мэдээлсэн байдлыг үнэлэн дүгнэлт өгч, илэрсэн асуудал зөвлөмж өгч, нэгдсэн тайлан мэдээг хүргүүлнэ.	Шилэн дансны тухай хуулийн 8.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, нийслэлийн Засаг даргын 2015 оны А/01 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2015 оны А/25 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн оролцоотой хуулийн этгээдүүдийн шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналтыг 2022 оны 3-р сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2021 оны жилийн эцсийн байдлаар 13	100

	даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр"-ийн 3.1.6 дахь заалт 2021 оны жилийн эцсийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд нийцлийн аудит хийх			92,1%-тай биелсэн байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2020 оны жилийн эцсийн байдалд "САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ" гэсэн үнэлгээг өгсөн.		байгууллагад явууллаа. 2021 оны жилийн эцсийн байдлаарх шилэн дансны мэдээллийн үйл ажиллагаа, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн байдлыг Сангийн яамны боловсруулсан ажлын хүснэгтээр үнэлж дүгнэвэл Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 90,0%-тай биелсэн байна.	
2.3	Шилэн дансны тухай хуулийн 8.2 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч	Албаны үйл ажиллагааны зардал	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн эхний хагас жилийн байдалд төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах 14 байгууллагуудыг хамруулан үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2021 оны хагас жилийн байдлаар 13 байгууллагад явуулсан. 2021 оны хагас жилийн байдлаарх шилэн дансны мэдээллийн үйл ажиллагаа, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн байдлыг үнэлж дүгнэвэл	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган 2021 оны эхний хагас жилийн байдлаар төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах 13 байгууллагууд мэдээлсэн байдлыг үнэлэн дүгнэлт өгч, илэрсэн асуудал зөвлөмж өгч, нэгдсэн тайлан мэдээг хүргүүлнэ.	Шилэн дансны тухай хуулийн 8.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, нийслэлийн Засаг даргын 2015 оны А/01 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2015 оны А/25 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн оролцоотой хуулийн этгээдүүдийн шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналтыг 2022 оны 7-р сард шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн	100

	хэрэгжүүлнэ” “Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн 3.1.6 дахь заалт 2022 оны хагас жилийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд нийцлийн аудит хийх			Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 90,2%-тай биелж “САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ” гэсэн дүгнэлтийг өгсөн.		2022 оны хагас жилийн байдлаар 13 байгууллагад явууллаа. 2022 оны хагас жилийн байдлаарх шилэн дансны мэдээллийн үйл ажиллагаа, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн байдлыг Сангийн яамны боловсруулсан ажлын хүснэгтээр үнэлж дүгнэвэл Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 92,4%-тай биелсэн байна.	
2.4	Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4 дэх хэсэгт заасан Сангийн сайдын 2017оны 365 дугаар тушаалаар баталсан	Албаны үйл ажиллагааны зардал	Хууль тогтоомж болон Сангийн сайдын Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу төлөвлөсөн эсэхийг хянах	Багахангай дүүргийн Дотоод аудитын албаны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний	Дүүргийн 2022 оны хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөлтийг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан эсэхийг үнэлэн дүгнэлт өгч, тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.	Багахангай дүүргийн Дотоод аудитын албаны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Засаг даргаар 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд нийцлийн аудит хийх удирдамжийг батлуулан аудит хийгдэж байна. Аудитын явцад хууль тогтоомжийн хэрэгжилт, ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хянан шалгаж байна.	90

	<p>“Худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийх журам-ын 2.1 дэх хэсэг Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм” 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн байдалд нийцлийн аудит хийх</p>			<p>төлөвлөлтөд нийцлийн аудит хийсэн. Аудитын явцад 2022 оны ОНХС-ийн нэгдсэн жагсаалтыг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулаагүй 1 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн. Дотоод аудитаар “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгсөн. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 12-р сарын 15-ны дотор албан бичгээр ирүүлэхийг тайланд тусгав. Зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь биелэсэн.</p>			
2.5	Сангийн	Албаны үйл	Дүүргийн	Орон нутгийн	Дүүргийн орон	Сангийн яамны нэгдсэн	100

<p>сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4 дэх хэсэгт заасан Сангийн сайдын 2017 оны 365 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийх журам-ын 2.1 дэх хэсэг Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм” 2022 оны хөрөнгө оруулалтын ажлын</p>	<p>ажиллагааны зардал</p>	<p>хөрөнгө оруулалтын арга хэмжээний санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналтыг хууль тогтоомж болон Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д нийцүүлэн зохион байгуулсан эсэхийг үнэлэн</p>	<p>хөгжлийн сангийн 2021 оны үйл ажиллагаанд нийцлийн аудит хийх явцад илэрсэн алдаа зөрчлүүдэд үндэслэн хяналтын орчин зохистой боловч зарим алдаа зөрчил, асуудал илэрсэн үед олгогддог “САЙЖРУУЛА ЛТ ХЭРЭГТЭЙ” үнэлгээг өгсөн байна.</p>	<p>нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх хөрөнгө оруулалтын арга хэмжээний санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналтыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан эсэхийг үнэлэн дүгнэлт өгч, тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.</p>	<p>удирдамжаар төлөвлөгөөт бус аудит хийгдсэн. Сангийн сайдын 2022 оны 10-р сарын 3-ны өдрийн шалгалт хийх нэгдсэн удирдамж, дүүргийн Засаг даргын 2022 оны 10-р сарын 19-ны өдрийн удирдамжийн дагуу дүүргийн цахилгаан, дулаан, уур ус, хогны үйлчилгээ үзүүлсэн байгууллагуудын 2020 оны 12-р сар, 2021 он, 2022 оны хагас жилд айл өрх, албан байгууллага, аж нэгжид цахилгаан, дулаан, уур усны үнийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгжийн хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийг нэхэмжилсэн тооцоонд шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтад цахилгаан дулааны эрчим хүч, дулааны уур, ус хангамж, ариутгах татуурга, хог хаягдлын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгж байгууллагууд болох Илч-Орд ОНӨААТҮГазар, Багахангай тохижилт ОНӨААТҮГазар, УСУГ-ын</p>
---	---------------------------	---	---	---	--

	гүйцэтгэлд нийцлийн аудит хийх		дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх			<p>харьяа Багахангай ус суваг ашиглалтын товчоо, УБЦТСүлжээ ХК-ний Налайх түгээх төвийн Багахангай хэсэг, УБТЗ-ын барилга засвар ашиглалт үйлчилгээний ангийн Багахангай хэсэг, УБТЗ-ын эрчим хүч усан хангамжийн 1-р ангийн Багахангай ЦШС-ний хэсэг зарим аж ахуйн нэгж, айл өрхийг түүвэрлэн хамруулсан. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх хөрөнгө оруулалтын арга хэмжээний санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналтыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан эсэхэд нийцлийн аудит хийхээр төсвийн ерөнхийлөн захирагчаар удирдамжийг батлуулан аудитын ажил хийгдэж байна.</p>	
--	--------------------------------------	--	--	--	--	---	--